



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 1/65

Амардалай

Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" 277 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2022 оны А/337 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хөдөө аж ахуйн салбар болон төв суурин газрын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах зарим арга хэмжээний тухай" Аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 03 тоот албан даалгавар, 2022-2023 оны Аймгийн Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын явцад хяналт тавих, хэрэгжилтийг тооцох үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Золжаргал (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Б.Баттогтох (ХАА-н мэргэжилтэн)

Гишүүд: Д.Наранцэцэг (МЭТ-ийн дарга)

Б.Довуучий (1-р багийн Засаг дарга)

Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)

Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

А.Адъяа (Ган-Илч ХХК Дэлгэрцогт салбарын дарга)

Ц.Шаравдагва (Ш/Үйлчилгээний засварын техникч)

Л.Амаржаргал (Сангууд хариуцсан нягтлан бодогч)

2."Хөдөө аж ахуйн салбар болон төв суурин газрын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөг боловсруулж, батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэхийг ажлын хэсэг (Л.Золжаргал), (Б.Баттогтох) нарт үүрэг болгосугай.

3.Засгийн газрын тогтоол, аймаг, сумын Засаг даргын албан даалгаврын хэрэгжилтийг 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн дотор зохион байгуулж, дүн мэдээг 10 дугаар сарын 25-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (Л.Золжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.БАЯРСҮХ